- Илүү анхаарал хандуулах, халамж тавих тусгайлсан бодлого, хөтөлбөр шаардлагатай газар нутгийн хувьд хэрэгжүүлж буй хөтөлбөр үйл, ажиллагааны үр дүнг үнэлэх, олон улсын түвшинд харьцуулахуйц боломжтой тоо мэдээллийг цуглуулах;
- Бусад мэдээллийн эх үүсвэрээс гаргадаггүй сэтгэл ханамж, хандлагын талаарх мэдээллийг цуглуулах.

Энэхүү тайлан нь “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018”-ийн үр дүнгийн тайлан юм. Тайлангийн хоёрдугаар бүлэг “Судалгааны арга зүй”-н хэсэгт түүврийн дизайн, судалгааны үйл явц, хэрэгжилтийн талаар дурдсан, “Үзүүлэлт, тодорхойлолт” хэсэгт судалгаанаас тооцогдож буй үзүүлэлтийн тодорхойлолтыг таницуулсан. Судалгааны үр дүнг тайлбарлахын өмнө судалгаанд хамрагдагчдын шинж байдлыг илтгэсэн хэсгийг “Түүврийн хамрах хүрээ ба судалгаанд хамрагдагчдын онцлог шинж” буюу дөрөвдүгээр бүлэгт оруулсан. Тавдугаар бүлгээс эхлэн судалгааны үр дүнг сэдэвчилж тайлагналаа. Бүлэг бүрийн эхэнд тухайн сэдвийн талаарх товч танилцуулга, хүснэгтийн талаар тайлбарыг, харин тухайн сэдэвтэй холбоотой үр дүнгийн хүснэгтийг бүлгийн төгсгөлд оруулсан.

“Эсэн мэнд амьдрал” гэсэн тавдугаар бүлэгт тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг тайлагнасан.

Дараагийн “Өсөлт хөгжил-Нөхөн үржихүйн болон эхийн эрүүл мэнд” гэсэн зургаа дугаар бүлэгт төрөлт, эрт төрөлт, Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээ (ЖСАХ), ЖСАХ-ийн хангагдаагүй хэрэглээ, жирэмсний хяналт, төрөх үеийн тусламж үйлчилгээ, нярайн жинлэсэн байдал, төрсний дараах хяналт, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)¹, хүний дархлалтын хомсдолын вирус (ХДХВ)/дархлалын олдмол хомсдол (ДОХ)-ийн мэдлэг, хөвч таслах, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэг¹, хүний папилома вирусийн талаарх мэдлэг¹, хандлага бүлгийн төгсгөл хэсэгт жирэмсний төгсгөл, үр хөндөлтийн¹ гэсэн сэдвүүдийг багтаасан.

“Өсөлт хөгжил-Хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил” гэсэн дараагийн бүлэгт дархлаажуулалт, бага насны хүүхдийн өвчлөл, суулгалт, өрхийн эрчим хүчний хэрэглээ, амьсгалын замын цочмог халдвар, нярай болон бага насны хүүхдийн хооллолт, хоол тэжээлийн дутагдал, иоджуулсан давсны хэрэглээ, бага насны хүүхдийн хөгжил зэргийг оруулсан.

“Сурах” гэсэн бүлэгт сургуулийн өмнөх боловсрол, сургуульд хамрагдалт, эцэг, эхийн оролцоо, сурах суурь чадварыг талаар оруулсан.

“Хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалагдах” бүлэг нь төрсний бүртгэл, хүүхдийн хүмүүжил, хүүхдийн хөдөлмөр, эрт гэрлэлт, хохирсон байдал, аюулгүй байдлыг мэдрэх, гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлагын талаар дэд сэдвийг багтаасан.

1 Эдгээр бүлгийг өөрийн улс орны онцлог, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн нэмж оруулсан.

“Аюулгүй, цэвэр орчин дахь амьдрах” буюу аравдугаар бүлэгт ундны ус, гар угаах газар, ариун цэврийн байгууламж, биений юм ирсэн үеийн ариун цэвэр сахих байдал зэргийг багтаасан.

“Амьдралын тэгш боломж” эцсийн бүлэг нь хүүхдийн үйлдлийн чадвар, ялгаварлан гадуурхалт, амьдралын

сайн сайхан байдал зэрэг тэгш боломжийг илтгэх сэдвийг агуулсан.

Тайлангийн төгсгөлд түүврийн дизайн, судалгаанд оролцогчдын нэрс, түүврийн алдааны тооцоолол, мэдээллийн чанарын хүснэгтүүд, асуулгын хуудсыг хавсралтаар оруулсан болно.

Монгол Улс Хүүхэд хөгжил судалгаа (ХХС)–г Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС)–ны аргачлалд тулгуурлан 1996, 2000, 2005, 2010 онуудад 4 удаа, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа (НҮЭМС)–г Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаа (ХАЗЭМС)–ны аргачлалыг баримтлан 1998, 2003, 2008 онуудад 3 удаа зохион байгуулсан.

ХХС, НҮЭМС–г 2 жилийн зайтайгаар ихээхэн хөрөнгө, хүн хүч, цаг хугацаа зарцуулан явуулдаг, аргачлал нь зарчмын зөрүүгүй, олон ижил үзүүлэлтийг тооцож, улс, бүсийн түвшинд үр дүнг тархаадаг зэргээс үүдэн Үндэсний статистикийн хорооноос нэгтгэн явуулах шаардлагатай гэж үзсэн. Тиймээс 2013 онд “Статистикийн тухай” Монгол улсын хуульд өөрчлөлт оруулан ХХС, НҮЭМС–г нэгтгэж ОУБТС–ны аргачлалыг ашиглан “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг 5 жил тутам” зохион байгуулахаар хуульчилсан.

2.1 ТҮҮВРИЙН ДИЗАЙН

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа өрхөд суурилсан судалгаа учраас түүврийн нэгж нь өрх юм.

Хүүхэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үзүүлэлтүүдийг үндэсний түвшинд, үүний дотор хот, хөдөө, бүсээр (Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар) болон зорилтот 6 аймаг (Баян–Өлгий, Завхан, Говь–Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Өмнөговь), 2 дүүрэг (Баянзүрх, Налайх)–ээр тооцоход хангалттай төлөөлөлтэй байхаар түүврийн хэмжээг тогтоосон.

НҮБ–ын Хүүхдийн Сангийн хүсэлт, санхүүжилтээр тус байгууллагын хөтөлбөр хэрэгжиж буй Баян–Өлгий, Завхан, Говь–Алтай, Баянхонгор, Хөвсгөл аймаг,

Баянзүрх, Налайх дүүргийг, уул уурхайд суурилан хөгжиж буй аймгийн дүр зургийг тодруулах зорилгоор “Оюу толгой” ХХК–ны санхүүжилт, НҮБ–ын Хүн Амын Сангийн хүсэлтийн дагуу Өмнөговь аймгийг тус тус зорилтод аймаг, дүүргээр сонгосон.

Улсын хэмжээнд 14,500 өрхийг судалгаанд хамруулж, бүс бүрт ногдох өрхийн тоог квадрат язгуурын аргаар тооцсон.

Өрхүүдийг сонгохдоо 2 шатлалт, бүлэглэсэн түүврийн аргыг ашиглав. Эхний шатанд судалгаанд хамрагдах түүврийн анхан шатны нэгжийг (сегмент) хэмжээнд нь пропорционал магадлалт түүврийн аргаар тодорхойлсон. Сонгогдсон ТАШН бүрийн хувьд өрхийн жагсаалтыг 2018 оны 8–9 сард шинэчлэн гаргуулсны дараа судалгаанд хамруулах өрхийн тоог 25 байхаар тооцож, өрхүүдийг системчилсэн магадлалт түүврийн аргаар сонголоо.

Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг хийхдээ түүврийн жин ашигласан. Түүврийн зохиомжтой холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт А (Түүврийн дизайн)–аас үзнэ үү.

2.2 СУДАЛГААНЫ АСУУЛГА

Судалгааны асуулга, үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо судалгааны зорилго, хамрах хүрээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлага, ОУБТС6–ын стандарт асуулга¹–д үндэслэсэн.

Судалгаанд доор дурдсан 7 асуулгыг оруулсан:

1. Өрхийн асуулга – өрхийн гишүүдийн хүн ам зүйн мэдээлэл болон сууцны талаарх мэдээллийг цуглуулсан.

1 ОУБТС–ны стандарт асуулгыг <http://mics.unicef.org/tools> цахим хуудаснаас харж болно.

2. Өрхийн усны чанар шалгах асуулга (*E.коли*) – түүврийн нэгж тус бүрээс 5 өрхийг сонгож хамруулсан.
3. Эмэгтэйн ганцаарчилсан асуулга – өрхийн 15–49 насны бүх эмэгтэйчүүдийг хамруулсан.
4. Эрэгтэйн ганцаарчилсан асуулга – хоёр өрх тутмын нэгт амьдардаг 15–49 насны бүх эрэгтэйчүүдийг хамруулсан.
5. 5 хүртэлх насны хүүхдийн асуулга – өрхөд амьдарч байгаа 5 хүртэлх насны хүүхдийн эх/ асран хамгаалагчаас асуулга авсан.
6. Өрх/ сумын эмнэлгээс вакцины мэдээллийг тэмдэглэх асуулга – 5 хүртэлх насны хүүхдийн асуулгад хамрагдсан 3 хүртэлх насны хүүхдийн вакцинжуулалтын мэдээллийг тухайн өрхийн амьдарч байгаа харьяа сум/ өрхийн эмнэлгээс авсан.
7. 5–17 насны хүүхдийн асуулга – өрхөд амьдарч байгаа 5–17 насны хүүхдийн нэгийг санамсаргүй аргаар сонгож хүүхдийн эх/ асран хамгаалагчаас асуулга авсан.²

Стандарт асуулгыг орчуулсны дараагаар энэ удаагийн судалгаанд шинээр орсон бүлгүүдийн хувьд 2017 оны 12 сард 6 удаагийн сэдэвчилсэн хэлэлцүүлгээр, бүх асуулгын хуудсыг 2018 оны 1 сард ажлын хэсгийн хурлаар тус тус хэлэлцэж, салбарын мэргэжилтнүүдээс нэмэлт үзүүлэлтийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж сайжруулсан.

Асуулга боловсруулахад дараах зарчим баримталсан. Үүнд:

1. Өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулах байдлыг хангах;
2. Бусад улс оронтой харьцуулах байдлыг хангах;
3. Өөрийн орны онцлог, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэх;

Асуулгын туршилтыг 2018 оны 5 сард Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Хушаат сум, Улаанбаатар хотын Налайх дүүргийн нийт 5 нэгжид зохион байгуулсан. Туршилтын судалгааны үр дүнд суурилан асуулгын хуудсанд зохих засвар хийж, асуулт хоорондын уялдааг сайжруулсан.

Асуулгад дараах модулиуд багтсан:

Өрхийн асуулга	Эмэгтэй / Эрэгтэйн ганцаарчилсан асуулга	5–17 насны хүүхдийн асуулга
Өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл Өрхийн гишүүдийн боловсрол Өрхийн зарим үзүүлэлт Өрхийн эрчим хүчний хэрэглээ Ус хангамж болон ариун цэврийн байгууламж Гар угаах газар Иоджуулсан давс	Ерөнхий мэдээлэл ^[Эр] Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээ ^[Эр] Амьд төрүүлсэн хүүхдийн тоо/ Төрсөн хүүхдийн тоо ^[Эр] Төрөлтийн түүх Жирэмслэлтийн төгсгөл ^[Нэмэлт] Төрөлтийн төлөвлөлт Эх, нялхсын эрүүл мэнд Төрсний дараах хяналт Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ Төрөлтийн төсөөлөл Гэрлэлтийн байдал ^[Эр] Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага ^[Эр] Хохирсон байдал ^[Эр] Насанд хүрэгчдийн үйлдлийн чадвар ^[Эр] Бэлгийн харьцааны төлөвшил ^[Эр] Бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ ДОХ–ын талаарх мэдлэг, хандлага ^[Эр] Умайн хүзүүний хорт хавдар ^[Нэмэлт] Хөвч таслах ^[Зөвхөн Эр] Тамхи, согтууруулах ундааны хэрэглээ ^[Эр] Амьдралын сэтгэл ханамж ^[Эр]	Ерөнхий мэдээлэл Хүүхдийн хөдөлмөр Хүүхдийн хүмүүжил Хүүхдийн үйлдлийн чадвар Эцэг, эхийн оролцоо Сурах суурь чадвар
Өрхийн усны чанар шалгах асуулга (<i>E.коли</i>)		5 хүртэлх насны хүүхдийн асуулга Ерөнхий мэдээлэл Төрсний бүртгэл Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил Хүүхдийн хүмүүжил Хүүхдийн үйлдлийн чадвар Эхийн сүүгээр хооллолт ба хүүхдийн хоол тэжээл Вакцинжуулалт Хүүхдийн өвчлөл, эмчилгээ, сувилгаа Хүүхдийн жин, өндрийн хэмжилт
Эрэгтэйн ганцаарчилсан асуулгад орсон бүлэгт ^[Эр] тэмдэглэгээ хийв.		Өрх/ сумын эмнэлгээс вакцины мэдээллийг тэмдэглэх асуулга
Өөрийн улс орны онцлог, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн нэмж оруулсан бүлэгт ^[Нэмэлт] тэмдэглэгээ хийв.		

2 ОУБТС–ны стандарт асуулгыг <http://mics.unicef.org/tools> цахим хуудаснаас харж болно.

Судалгааны багууд асуулга авахаас гадна өрхийн хэрэглэдэг давсны иодын агууламж тодорхойлох, гар угаах газар болон угаалтуурт ажиглалт хийх, 5 хүртэлх насны хүүхдийн жин, өндрийг хэмжих, ундны ус болон усны эх үүсвэрт *E.коли* илрүүлэх шинжилгээ хийх зэрэг ажлыг гүйцэтгэсэн. Эдгээр ажиглалт, хэмжилтийн үр дүнг тайлангийн холбогдох хэсгүүдэд танилцуулсан. Түүнчлэн 5–17 насны хүүхдийн асуулгад 7–14 насны хүүхдээр уншуулж, тоо бодох дасгал хийлгэж үнэлгээ хийх бүлэг орсон.

Судалгааны асуулгыг Хавсралт F–ээс харж болно.

2.3 СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙ

Судалгааны үзэл баримтлалыг ҮСХ–ны даргын 2018 оны А/67 тоот тушаалаар баталсан, үүнд судалгааг зохион байгуулах явцад гарч болзошгүй аливаа эрсдэл, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тусгасан.

Судалгаанд сонгогдсон өрх, тухайн өрхөд амьдарч байгаа судалгаанд хамрагдах насны хүн бүрээс зөвшөөрөл авч ярилцлага хийсэн. 15–17 насны өсвөр насны хүүхдүүдийн хувьд зөвшөөрлийг өөрсдөөс нь авахаас өмнө тэдний эх, асран хамгаалагчаас авсан. Судалгаанд хамрагдсан хүн бүрт сайн дурын үндсэн дээр оролцох, хувь хүний мэдээллийн нууцлалыг хуулийн дагуу чандлан хадгалж, мэдээллийг нэргүйгээр ашиглах тухайгаа танилцуулсан. Түүнчлэн судалгаанд хамрагдсан хүн нь бүх, эсвэл аль нэг асуултад хариулахаас татгалзах, ярилцлагыг хэзээ ч зогсоох эрхтэй гэдгийг урьдчилан сануулж байв.

Давсны иодын агууламжийг шалгаад гарсан үр дүнг өрхөд танилцуулж байсан. Харин ундны усанд *E.коли* байгаа эсэхийг шалгасан үр дүнг тухайн орон нутгийн удирдлагуудад багийн ахлагч нар мэдээлж байв.

2.4 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА

НҮТС–ны мэдээлэл цуглуулалтад компьютер ашиглан ярилцлага авах (CAPI) аргыг хэрэглэсэн. Судалгааны мэдээлэл цуглуулалтын CPro 6.3 (тооллого, түүвэр судалгааны мэдээлэл боловсруулах систем) програмыг ашигласан бөгөөд ОУБТС6–ын стандарт програмд суурилж³, өөрийн орны асуулгатай уялдуулан шаардлагатай өөрчлөлтийг тусган боловсруулсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад ашиглах програмын туршилтын судалгааг Хэнтий аймгийн Хэрлэн, Баян–Овоо сум, Улаанбаатар хотын Багануур дүүрэгт 2018 оны 7 сарын 23–наас 8 сарын 2–нд зохион байгуулав. Уг туршилтын судалгаанаас гарсан үр дүнд үндэслэн асуулга болон програмд шаардлагатай засвар, өөрчлөлт хийж эцэслэн боловсрууллаа.

2.5 СУРГАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтнуудад зориулсан сургалтыг 160 хүнийг хамруулж, 8 сарын 20–ноос 9 сарын 21–ний хооронд нийт 30 хоногийн хугацаанд зохион байгуулсан. Сургалтад ярилцлага авах арга зүй, асуулгын хуудас тус бүрийн асуултыг зааснаас гадна цаасан асуулгаар, таблет ашиглан бие биесээс нь ярилцлага авахуулсан. Сургалтын эхний 20 хоногт цаасан асуулга, үлдсэн 10 хоногт нь таблетийн хичээл заав.

Сургалтын явцад цаасан асуулгын дадлагыг 2 өдөр Баянзүрх дүүргийн 2 дугаар хороонд, таблет асуулгын дадлагыг мөн 2 өдөр Баянзүрх дүүргийн 5 дугаар хороонд зохион байгуулж айлуудаар орж судалгаа авсан. Сургалтын хөтөлбөр, зохион байгуулалтыг ОУБТС6–ын стандарт хөтөлбөрийг⁴ үндэслэн боловсруулж, зохион байгуулсан. Мөн онцгой байдлын нөхцөлд хэрхэн ажиллах, нохойтой хэрхэн харьцах, харилцааны болон багийн сэтгэлзүйн талаар нэмэлт хичээлийг хөтөлбөртөө тусган оруулсан.

Сургалтын явцад хүүхдийн өндөр, жин хэмжих, усны чанар шалгах хичээлийг 4 өдөр тусгайлан зааж, хүүхдийн өндөр, жин хэмжих дадлага 1 өдөр, усны чанар шалгах дадлага 1 өдөр хийсэн.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн ахлагчаар ажиллах хүмүүстээ багийн ахлагчийн үүрэг, хариуцлага, хийх ажлын талаар, мэдээлэл цуглуулалтыг орон нутагт хэрхэн зохион байгуулах тухай нэмэлт сургалтыг зохион байгуулав.

2.6 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулалтад нийт 19 баг ажилласан, баг тус бүр багийн ахлагч, 5 ярилцлага авагч (2 эрэгтэй нь хүүхдийн өндөр, жин хэмжих, усны чанар

3 ОУБТС6–н стандарт мэдээлэл цуглуулах аппликейшний мэдээллийг дараах хаягаар үзэж болно : “MICS6 TOOLS.” Home – UNICEF MICS. 2018 оны 8–р сарын 23–ны байдлаар. <http://mics.unicef.org/tools#data-processing>.

4 Сургалтын хөтөлбөрийн загварыг дараах хаягаар үзэж болно: “MICS6 TOOLS.” Home – UNICEF MICS. 2018 оны 8–р сарын 23–ны байдлаар. <http://mics.unicef.org/tools#survey-design>.

шалгах тест хийх ажлыг хариуцан гүйцэтгэсэн)⁵, 2 жолооч гэсэн бүрэлдэхүүнтэй байв. Мэдээлэл цуглуулалтын ажил 2018 оны 9 сарын 21–нээс Улаанбаатар хотод, 10 сарын 3–наас орон нутагт эхэлж 12 сарын 28–ныг дуустал нийт 99 хоног үргэлжилсэн.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад Windows 10 үйлдлийн систем бүхий таблет ашигласан бөгөөд Bluetooth програмын тусламжтай багийн гишүүд өөр хоорондоо шаардлагатай мэдээллийг дамжуулж байв.

2.7 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

Багийн ахлагч ярилцлага авагч нарын цуглуулсан мэдээлэл, ярилцлага авах ур чадвар, гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж ажилласан. Мөн түүврийн нэгж бүрээс 2 өрхийг сонгон өрхийн гишүүдийн ерөнхий мэдээллийг албан ёсоор дахин авч ярилцлага авагчийн авсан асуулгатай тулгалт хийж байсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын явцад ҮСХ болон НҮБ–ын Хүүхдийн Сан, НҮБ–ын Хүн Амын Сангийн ажилтнууд мэдээлэл цуглуулалтын байдалтай танилцаж, шалгах аргаар баг тус бүрт 2 удаа очиж багийн зохион байгуулалт, ярилцлага авч байгаа байдлыг хянаж, холбогдох заавар зөвлөмжийг өгч ажилласан.

Мөн мэдээлэл цуглуулалтын явцын хяналтын хүснэгтүүдийг долоо хоногт 2 удаа гаргаж дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнд суурилан баг тус бүртээ холбогдон заавар зөвлөмж өгч, шаардлагатай арга хэмжээг авч байв. Мэдээлэл цуглуулалтын явцын хяналтын хүснэгтүүдийг ОУБТС–ны стандарт хүснэгтэд⁶ суурилан өөрийн орны онцлогийг тусган боловсруулж ашигласан.

2.8 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Мэдээлэл цуглуулалтын явцад ярилцлага авагч нарын цуглуулсан мэдээлэл багийн ахлагчийн таблет дээрх програмд нэгтгэгдэж, тухай бүр хянаж, шаардлагатай тодруулгыг хийсний дараа багийн ахлагч интернэт ашиглан ҮСХ–ны төв серверт нэгтгэсэн мэдээллийг дамжуулж⁷ байв. Програмд шинэчлэл хийсэн тохиолдолд багийн ахлагч ҮСХ–ны төв серверт мэдээлэл дамжуулах үед багийн ахлагчийн программ шинэчлэгдэхээр зохион байгуулсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалт дууссаны дараа мэдээллийн уялдааг шалган шаардлагатай засвар хийхдээ ОУБТС6–ын стандарт удирдамжийг⁸ мөрдөж байлаа.

Судалгааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг тооцож, хүснэгтлэн боловсруулахдаа Нийгмийн шинжлэх ухаанд ашигладаг статистикийн багц програм SPSS 24.0–ийг ашигласан. Мөн судалгааны үр дүнг боловсруулахдаа ОУБТС6–ын стандарт синтакс, хүснэгтийг⁹ ашиглахаас гадна өөрийн улс орны хэрэгцээ шаардлага, онцлогт суурилан шаардлагатай хүснэгт, үзүүлэлтүүдийг нэмж тооцсон болно.

2.9 АНХАН ШАТНЫ МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

ҮСХ нь мэдээллийн нууцлалыг хадгалах зорилгоор анхдагч мэдээллийн базаас өрхийн хаяг болон хувь хүмүүсийн нэр зэрэг өрх, хүн амыг таних үзүүлэлтийг хассан. Өрх болон хувь хүний нууцлалыг хангасан анхан шатны мэдээллийг ҮСХ болон НҮБ–ын Хүүхдийн Сангийн цахим хуудсанд¹⁰ байршуулж хэрэглэгчдэд судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах боломжийг олгодог.

Судалгааны зохион байгуулалтын бүхий л үе шатны мэдээллийг баримтжуулж архивласан. Мөн мета мэдээллийн санг үүсгэж олон нийтэд нээлттэй ашиглуулдаг.

5 ОУБТС–ны стандарт удирдамжийн дагуу зөвхөн хэмжилт, туршилт гүйцэтгэх тусдаа хэмжигч багийн бүрэлдэхүүнд байдаг.

6 Судалгаа авах ажлын хяналтын хуудасны загварыг дараах хаягаар авах боломжтой: "MICS6 TOOLS." Home – UNICEF MICS. 2018 оны 8–р сарын 23–ны байдлаар. <http://mics.unicef.org/tools#data-collection>.

7 ОУБТС6–ын хүрээнд санал болгосон интернэт файл дамжуулах систем буюу IFSS–ийг ашиглаагүй.

8 Стандарт удирдамжийг дараах хаягаар авах боломжтой: "MICS6 TOOLS." Home – UNICEF MICS. 2018 оны 8–р сарын 23–ны байдлаар. <http://mics.unicef.org/tools#data-processing>.

9 Стандарт тооцооллын төлөвлөгөө болон синтакс файлуудыг дараах хаягаар үзэж болно: "MICS6 TOOLS." Home – UNICEF MICS. 2018 оны 8–р сарын 23–ны байдлаар. <http://mics.unicef.org/tools#analysis>

10 Судалгааны анхдагч мэдээллийг дараах хаягаар авах боломжтой: "MICS6 TOOLS." Home – UNICEF MICS. 2018 оны 8–р сарын 23–ны байдлаар. <http://mics.unicef.org/tools#data-processing>.

ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

ҮЗҮҮЛЭЛТ	ТХЗ ¹	Бүлэг ²	Тодорхойлолт ³	Утга	
СУДАЛГААНЫ ХАМРАЛТ, СУДАЛГААНД ХАМРАГДАГЧИЙН ШИНЖ БАЙДАЛ					
SR.1	Цахилгаан эрчим хүчний хангамж	7.1.1	НС	Цахилгаан эрчим хүчтэй өрхөд амьдардаг хүн амын хувь	98.1
SR.2	Бичиг үсэг тайлагдалтын түвшин		WB	Энгийн богино хэмжээний өгүүлбэрийг унших чадвартай, эсвэл суурь болон түүнээс дээш боловсролтой 15–24 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	99.3 97.6
SR.3	Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ		MT	Долоо хоногт наад зах нь 1 удаа сонин, хэвлэл уншиж, радио, FM сонсож, телевиз үздэг 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	4.5 7.5
SR.4	Радиотой өрх		НС	Радиотой өрхийн хувь	6.2
SR.5	Зурагтай өрх		НС	Зурагтай өрхийн хувь	92.6
SR.6	Утастай өрх		НС – MT	Утастай (суурин болон гар утас) өрхийн хувь	98.9
SR.7	Компьюертэй өрх		НС	Компьюертэй өрхийн хувь	30.6
SR.8	Интернэттэй өрх		НС	Гэртээ интернэттэй өрхийн хувь	36.1
SR.9	Компьютерийн хэрэглээ		MT	Судалгаанаас өмнөх 3 сард компьютер хэрэглэсэн 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	36.2 35.3
SR.10	Гар утастай хүн	5.b.1	MT	Гар утастай 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	97.0 95.5
SR.11	Гар утасны хэрэглээ		MT	Судалгаанаас өмнөх 3 сард гар утас хэрэглэсэн 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	97.2 94.5

- 1 ТХЗ–ын үзүүлэлтүүд, <http://unstats.un.org/sdgs/indicators/indicators-list/>. ТХЗ–ын үзүүлэлтийг хариуцсан ажлын хэсэг нь олон тооны үзүүлэлтүүдийн метадатаг шинэчилж байгаа бөгөөд үзүүлэлтийн жагсаалтад мөн өөрчлөлт оруулж байгаа. ОУБТС–ны хүрээ нь ТХЗ–ын маш олон үзүүлэлтийг тодорхойлолттой нь бүрэн тохирох байдлаар хамарч байгаа бөгөөд цөөн тооны ТХЗ–ын үзүүлэлтийг ОУБТС бүрэн бус хамардаг. Судалгааны хүрээнд бүрэн хамардаггүй үзүүлэлтүүдийн хувьд одоогийн хэрэглэж буй ОУ–ын аргачлал нь зөвхөн ОУБТС–ны тодорхойлолтыг баримталдаг учраас, мөн тухайн ТХЗ–ын үзүүлэлтийн чухал мэдээллийг бий болгодог учир энэхүү жагсаалтад багтаасан. ТХЗ–ыны үзүүлэлтийн мета мэдээллийн талаар илүү дэлгэрэнгүйг <http://unstats.un.org/sdgs/metadata/> холбоосоор авч болно.
- 2 Зарим үзүүлэлтүүд нь ОУБТС–ны асуулгын хэд хэдэн бүлгийн асуултыг ашиглан тооцогдсон. Энэ тохиолдолд үзүүлэлтийг тооцоход шаардлагатай дийлэнх мэдээллийг агуулж байгаа бүлэг/ бүлгүүдийг энд үзүүлсэн.
- 3 ОУБТС–ны бүх үзүүлэлтүүд холбогдох шинж байдлаар, тухайлбал, аж байдлын индекс, хүйс, нас, өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа, шилжих хөдөлгөөнд оролцсон байдал, хөгжлийн бэрхшээл болон газар зүйн байршил (тайланг задлан үзүүлэх үндсэн нэгжүүдээр), Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)–ын үзүүлэлтүүдийн Олон улсын хамтарсан мэргэжилтнүүдийн бүлгийн зөвлөмжийн дагуу <http://unstats.un.org/sdgs/indicators/Official%20List%20of%20Proposed%20SDG%20Indicators.pdf> бусад шинж байдлаар ангилсан.

SR.12a SR.12b	Интернэтийн хэрэглээ	17.8.1	MT	Интернэт хэрэглэсэн 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй (a) Судалгаанаас өмнөх 3 сард интернэт хэрэглэсэн (b) Судалгаанаас өмнөх 3 сард долоо хоногт наад зах нь нэг удаа интернэт хэрэглэсэн Эрэгтэй (a) Судалгаанаас өмнөх 3 сард интернэт хэрэглэсэн (b) Судалгаанаас өмнөх 3 сард долоо хоногт наад зах нь нэг удаа интернэт хэрэглэсэн	73.6 69.2 63.9 59.5
SR.13a SR.13b	Мэдээлэл харилцааны технологи ашиглах чадвар	4.4.1	MT	Судалгаанаас өмнөх 3 сард компьютертэй холбоотой тусгайлсан 9 үйлдлүүдээс наад зах нь нэгийг нь хийсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй (a) 15–24 насны (b) 15–49 насны Эрэгтэй (a) 15–24 насны (b) 15–49 насны	42.9 31.6 44.9 29.7
SR.14a	Тамхины хэрэглээ	3.a.1	TA	Судалгаанаас өмнөх 1 сард янжуур тамхи, навчин тамхи, дүнсэн тамхи гэх мэт утаатай төрлийн тамхи татсан, эсвэл хамрын тамхи, зажилдаг тамхи гэх мэт утаагүй төрлийн тамхи хэрэглэсэн 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	9.2 58.0
SR.14b	Тамхи хэрэглэдэггүй хүн ам	3.8.1	TA	Судалгаанаас өмнөх 1 сард янжуур тамхи, навчин тамхи, дүнсэн тамхи гэх мэт утаатай төрлийн тамхи, эсвэл хамрын тамхи, зажилдаг тамхи гэх мэт утаагүй төрлийн тамхи огт хэрэглээгүй 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	90.8 43.5
SR.15	15 нас хүрэхээсээ өмнө тамхи татаж үзсэн хүн ам		TA	15 нас хүрэхээсээ өмнө ширхэг янжуур тамхийг бүтнээр нь татсан 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	1.1 16.4
SR.16	Архи, согтууруулах ундааны хэрэглээ		TA	Судалгаанаас өмнөх 1 сард архи, согтууруулах ундаа (наад зах нь нэг лааз, эсвэл нэг шил шар айраг, эсвэл хундага дарс, эсвэл нэг хундага архи, коньяк, виски) уусан 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	27.4 47.2
SR.17	15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа ууж үзсэн хүн ам		TA	15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа (наад зах нь нэг лааз эсвэл нэг шил шар айраг, эсвэл хундага дарс, эсвэл нэг хундага архи, коньяк, виски) ууж үзсэн 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	0.7 3.1
SR.18	Төрсөн эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхэд		HL	Төрсөн эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй 0–17 насны хүүхдийн хувь	7.7
SR.19	Хагас, бүтэн өнчин хүүхэд		HL	Хагас, бүтэн өнчин 0–17 насны хүүхдийн хувь	6.0
SR.20	Эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхэд		HL	Төрсөн эцэг, эхийн хэн нэг нь эсвэл хоёулаа гадаадад амьдардаг 0–17 насны хүүхдийн хувь	2.0
ЭНДЭГДЭЛ ⁴					
CS.1	Нярайн эндэгдлийн түвшин	3.2.2	BH	1 сар хүрэхээсээ өмнө эндэх магадлал	9

4 Эндэгдлийн үзүүлэлтүүдийг сүүлийн 5 жилийн хугацааг хамруулан тооцсон.

CS.2	Нярайн дараах эндэгдлийн түвшин		BH	Нялхас болон нярайн нас баралтын эндэгдлийн түвшний зөрүү	7
CS.3	Нялхсын эндэгдлийн түвшин		CM / BH	1 нас хүрэхээсээ өмнө эндэх магадлал	16
CS.4	Хүүхдийн эндэгдлийн түвшин		BH	Хүүхэд 1–4 настайдаа эндэх магадлал	4
CS.5	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	3.2.1	CM / BH	5 нас хүрэхээсээ өмнө эндэх магадлал	19

НӨХӨН ҮРЖИХҮЙ БОЛОН ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНД

TM.1	Өсвөр насны охидын төрөлтийн түвшин	3.7.2	CM / BH	15–19 насны бүлэг дэх төрөлтийн коэффициент	42.6
TM.2	Эрт төрөлт		CM / BH	18 нас хүрэхээсээ өмнө хүүхэд төрүүлсэн 20–24 насны эмэгтэйчүүдийн хувь	4.2
TM.3	ЖСАХ–ийн хэрэглээ		CP	ЖСАХ (орчин үеийн эсвэл уламжлалт арга) хэрэглэж байгаа (нөхөр, хамтран амьдрагч нь хэрэглэдэг байж болно) гэрлэсэн, эсвэл хамтран амьдрагчтай 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	48.1
TM.4	ЖСАХ–ийн хангагдсан хэрэгцээ ⁵	3.7.1 & 3.8.1	UN	Гэрлэсэн, эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд гэр бүл төлөвлөхдөө ЖСАХ–ийн орчин үеийн арга хэрэгслийг хэрэглэж байгаа 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	63.9
TM.S1	ЖСАХ–ийн хэрэглээ, бэлгийн хавьтал, нөхөн үржихүйн эрүүл мэнддээ анхаарах талаар бие даан шийдвэр гаргадаг эмэгтэйчүүд (өөрийн улс орны онцлогт суурилж тооцсон)	5.6.1	DV	Гэрлэсэн, эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд ЖСАХ–ийг ер нь хэрэглэж байсан ЖСАХ–ийн хэрэглээ, бэлгийн хавьтал, нөхөн үржихүйн эрүүл мэнддээ анхаарах талаар бие даан шийдвэр гаргадаг 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	38.7
TM.5a TM.5b TM.S2 TM.5c	Жирэмсний хяналтад хамрагдалт		MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ тээж байхдаа жирэмсний хяналтад орсон 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь (a) наад зах нь 1 удаа мэргэжлийн эмчийн (b) наад зах нь 4 удаа ямар нэг хүний (c) наад зах нь 6 удаа мэргэжлийн эмчийн (өөрийн улс орны онцлогт суурилж тооцсон) (d) наад зах нь 8 удаа ямар нэг хүний	99.1 88.5 72.4 47.0
TM.6	Жирэмсний хяналтын бүрэлдэхүүн		MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ тээж байх үеийн жирэмсний хяналтын явцад байхдаа наад зах нь 1 удаа цусны даралтаа хэмжүүлж, шээс болон цусны шинжилгээ өгсөн эмэгтэйчүүдийн хувь	96.4
TM.8	Эмнэлгийн төрөлт		MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ эмнэлэгт төрүүлсэн 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	98.4
TM.9	Мэргэжлийн эмчийн хяналтад явагдсан төрөлт	3.1.2	MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ мэргэжлийн эмчийн хяналтад төрүүлсэн 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	99.3
TM.10	Мэс заслын аргаар төрүүлсэн төрөлт		MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ мэс заслын аргаар төрүүлсэн 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	26.2
TM.11	Төрсөн даруй нь жинлэсэн хүүхэд		MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ төрүүлсэн, төрсөн даруй хүүхдийг нь жинлэсэн 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	99.3

5 Хүснэгт TM.3.3–ээс дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.

TM.12	Төрсний дараа эмнэлэгт байсан хугацаа		PN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ төрүүлсний дараа эмнэлэгт 12, түүнээс дээш цаг байсан 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	98.1
TM.13	Төрсний дараах хүүхдийн хяналт		PN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ төрүүлсэн, төрсөн даруй эмнэлэг дэх нярайн үзлэг, гэрийн төрөлтийн хувьд төрөлтийг удирдсан хүний төрсөн даруйх нярайн үзлэг, эсвэл төрсний дараах 2 хоногийн доторх нярайн ТДХ эргэлт/ үзлэгт хүүхэд нь хамрагдсан 15–49 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	98.2
TM.14	Нярайг хуурайшуулсан байдал		MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ төрүүлсэн, төрсөн даруй хүүхдийг нь хуурайшуулсан, 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	79.6
TM.15	Нярайд дулаан байлгах асаргаа хийсэн байдал		MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ төрүүлсэн, төрсөн даруй хүүхдэд нь дулаан байлгах асаргаа хийсэн, 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	58.6
TM.S3	Нярайд дулаан байлгах асаргаа хийсэн байдал (өөрийн улс орны онцлогт суурилж тооцсон)		MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ төрүүлсэн, төрсөн даруй хүүхдэд нь дулаан байлгах асаргаа хийсэн, 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь (Дулаан байлгах асаргаанд нярайд малгай өмсгөсөн тохиолдлыг нэмж оруулсан.)	41.5
TM.16	Нярайг усанд оруулахыг хойшлуулсан байдал		MN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ төрүүлсэн, төрснөөс хойш 24, түүнээс дээш цагийн дараа хүүхдийг нь усанд оруулсан, 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	69.8
TM.19	Төрсний дараах үйлчилгээ авсан байдал		PN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ төрүүлсэн, төрсний дараах 2 хоногт нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээнээс наад зах нь хоёр үйлчилгээг авсан, 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	93.8
TM.20	Төрсний дараах эхийн хяналт		PN	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ төрүүлсэн, төрсөн даруй эмнэлэг дэх үзлэг, гэрийн төрөлтийн хувьд төрөлтийг удирдсан хүний төрсөн даруйх үзлэг, эсвэл төрсний дараах 2 хоногийн доторх эхийн ТДХ эргэлт/ үзлэгт хамрагдсан 15–49 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	94.1
TM.22	Бэлгийн олон хавьтагчтай хүн		SB	Сүүлийн 12 сард нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь	1.3 6.6
TM.23	Бэлгийн олон хавьтагчтай бөгөөд хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн хүн		SB	Сүүлийн 12 сард нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон бөгөөд хамгийн сүүлийн бэлгийн хавьтлын үед бэлгэвч хэрэглэсэн 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь	21.1 49.4
TM.24	15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон залуу хүн		SB	15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон 15–24 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь	0.7 4.9
TM.25	Бэлгийн хавьталд орж байгаагүй залуу хүн		SB	Бэлгийн хавьталд орж байгаагүй 15–24 насны огт гэрлээгүй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь	73.9 49.0
TM.26	Бэлгийн хавьтагчийн насны зөрүү		SB	Сүүлийн 12 сард 10, түүнээс олон насаар ах хүнтэй бэлгийн хавьталд орсон 15–24 насны эмэгтэйчүүдийн хувь	3.0
TM.27	Тохиолдлын бэлгийн хавьталд орсон хүн		SB	Сүүлийн 12 сард тохиолдлын бэлгийн хавьталд орсон 15–24 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь	35.7 73.6

TM.28	Тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн хүн		SB	Сүүлийн 12 сард тохиолдлын бэлгийн хавьталд орсон бөгөөд хамгийн сүүлийн тохиолдлын бэлгийн хавьтлын үед бэлгэвч хэрэглэсэн 15–24 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	41.8 73.1
TM.29	ХДХВ-ийн халдвараас сэргийлэх цогц мэдлэгтэй залуу хүн		HA	ХДХВ-ийн халдвар бэлгийн замаар дамжихаас сэргийлэх 2 аргыг зөв тодорхойлсон ⁶ , эрүүл харагдаж буй хүн ХДХВ-ийн халдвартай байж болно гэдгийг мэддэг, үндсэн 2 ташаа ойлголтууд (шумууланд хазуулснаар ХДХВ халдвар авч болно, ХДХВ-ийн халдвартай хүнтэй хоол хүнсээ хувааж хэрэглэснээр халдвар дамжих боломжтой)–ыг үгүйсгэсэн 15–24 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	20.2 20.2
TM.30	ХДХВ-ийн халдвар эхээс ураг эсвэл нярайд дамжих боломжтой гэдгийг мэддэг хүн		HA	ХДХВ-ийн халдвар эхээс ураг, нярайд дамжих боломжтой гурван замыг ⁷ мэддэг 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	31.7 22.6
TM.31	ХДХВ-ийн халдвартай хүнийг ялгаварлан гадуурхах хандлагатай хүн		HA	ХДХВ-ийн халдвартай хүнийг ялгаварлан гадуурхах ⁸ хандлага илэрхийлсэн хариулт өгсөн 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	64.9 62.2
TM.32	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх газрыг мэддэг хүн		HA	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хаана өгөхийг мэддэг 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	73.0 59.5
TM.33	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч хариугаа авсан хүн		HA	Судалгааны өмнөх 12 сард ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан 15–49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	26.0 16.8
TM.34	Бэлгийн идэвхтэй амьдралтай, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан залуу хүн		HA	Судалгааны өмнөх 12 сард бэлгийн хавьталд орсон бөгөөд энэ хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан 15–24 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь Эмэгтэй Эрэгтэй	35.6 16.9
TM.35a TM.35b	Жирэмсний хяналтын явцад ХДХВ-ийн халдварын талаар зөвлөгөө авсан эмэгтэйчүүд		HA	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ тээж байх үеийн жирэмсний хяналтын явцад (а) ХДХВ-ийн халдварын талаар зөвлөгөө авсан ⁹ (б) ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч хариугаа авахдаа зөвлөгөө, мэдээлэл авсан 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	21.1 17.6

6 Халдвар аваагүй бэлгийн нэг үнэнч хавьтагчтай байх, бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэх

7 Жирэмсэн үед, төрөх үед, хүүхдээ хөхүүлэх үед дамждаг

8 Дараах 2 асуултад үгүй гэж хариулсан эмэгтэйчүүд: 1) Хэрвээ худалдагчийг ХДХВ-ийн халдвартай гэж мэдвэл та шинэ ногоо худалдан авах уу? 2) ХДХВ-ийн халдвартай хүүхэд халдваргүй хүүхдүүдтэй хамт нэг сургуульд сурч болно гэж та бодож байна уу?

9 Ярилцлага өгөгчөөс дараах гурван зөвлөгөөг авсан эсэхийг асуусан: 1) ХДХВ-ийн халдвар эхээс ураг, нярайд дамждаг, 2) ХДХВ-ийн халдвар авахаас сэргийлэх арга зам болон 3) ХДХВ-ийн шинжилгээ өгөх талаар

TM.36	Жирэмсний хяналтад хамрагдахдаа ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгсөн эмэгтэйчүүд		HA	Судалгааны өмнөх 2 жилд сүүлийн хүүхдээ тээж байх үеийн жирэмсний хяналтын явцад ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	53.0
TM.37	Хөвч таслалт		MMC	Хөвчөө таслуулсан 15–49 насны эрэгтэйчүүдийн хувь	4.8
TM.S4	Үр хөндөлтийн харьцаа		AB/BN	1,000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлтийн тоо	125.0
TM.S5	Үр хөндөлтийн тусгай коэффициент		AB	15–49 насны 1,000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн тоо	13.4
TM.S6	Үр хөндөлтийн нийлбэр коэффициент		AB	15–49 насны эмэгтэйд ногдох үр хөндөлтийн нийлбэр коэффициент ¹⁰	0.4
TM.S7	Эмнэлгийн үр хөндөлт (өөрийн улс орны онцлогт суурилж тооцсон)		AB	Судалгааны өмнөх 2 жилд үр хөндүүлсэн бөгөөд хамгийн сүүлийн үр хөндөлтөө эмнэлэгт хийлгэсэн 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь	98.5

ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХООЛ ТЭЖЭЭЛ БОЛОН ХӨГЖИЛ

ТС.1	Сүрьеэгийн эсрэг вакцинд хамрагдалт		IM	Судалгааны өмнөх хугацаанд сүрьеэгийн эсрэг (BCG) вакцинд хамрагдсан 12–23 сартай хүүхдийн хувь	98.0
ТС.2	Халдварт саагийн эсрэг вакцинд хамрагдалт		IM	Судалгааны өмнөх хугацаанд халдварт саагийн эсрэг вакцины (OPV) 3–р тунд хамрагдсан 12–23 сартай хүүхдийн хувь	92.0
ТС.3 ТС.4 ТС.5	Сахуу, хөхүүл ханиад, татран, гепатит Б, хемофилюс инфлюэнза Б (тавт) вакцинд хамрагдалт	3.b.1 & 3.8.1	IM	Судалгааны өмнөх хугацаанд тавт/ гуравт (Сахуу, татран, хөхүүл ханиад, Б гепатит, хемофилюс инфлюэнза Б–гийн эсрэг) (Penta3) вакцины 3–р тунд хамрагдсан 12–23 сартай хүүхдийн хувь	91.9
	Б гепатит (тавт) эсрэг вакцинд			Судалгааны өмнөх хугацаанд тавт (Сахуу, татран, хөхүүл ханиад, Б гепатит, хемофилюс инфлюэнза Б–гийн эсрэг) (Penta3) вакцины 3–р тунд хамрагдсан 12–23 сартай хүүхдийн хувь	91.9
	Хемофилюс инфлюэнза Б (Хиб)–ийн эсрэг вакцинд хамрагдалт			Судалгааны өмнөх хугацаанд тавт (Сахуу, татран, хөхүүл ханиад, Б гепатит, хемофилюс инфлюэнза Б–гийн эсрэг) (Penta3) вакцины 3–р тунд хамрагдсан 12–23 сартай хүүхдийн хувь	91.9
ТС.8 ТС.10	Улаануудын эсрэг вакцинд хамрагдалт Улаан бурханы эсрэг вакцинд хамрагдалт	3.b.1	IM	Судалгааны өмнөх хугацаанд улаанбурхан, гахайн хавдар, улаануудын (УГУ) эсрэг вакцинд хамрагдалт	
				a) 1–р тунд хамрагдсан 12–23 сартай хүүхдийн хувь b) 2–р тунд хамрагдсан 30–35 сартай хүүхдийн хувь	91.6 81.3
ТС.11a ТС.11b	Бүх вакцинд хамрагдсан (суурь дархлаажуулалт)		IM	Судалгааны өмнөх хугацаанд дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу	86.9
	Бүх вакцинд хамрагдсан (бүрэн дархлаажуулалт)			a) Нэг нас хүрэхээс өмнөх товлотт вакцинд хамрагдсан 12–23 сартай b) Товлолт бүх вакцинд хамрагдсан 30–35 сартай хүүхдийн хувь	68.8
ТС.12	Суулгалт өвчний үед мэргэжлийн эмчид хандсан байдал		CA	Судалгааны өмнөх 2 долоо хоногт суулгалтаар өвдсөн бөгөөд эмнэлэг, мэргэжлийн эмчид хандсан 5 хүртэлх насны хүүхдийн хувь	51.3

10 Насны бүлэг дэх үр хөндөлтийн коэффициент (НБҮХК) нь тухайн насны бүлэг дэх 1,000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн тоогоор илэрхийлэгдэх ба насны бүлэг дэх үр хөндөлтийн хэв маягийг харуулах юм. НБҮХК–ын хүртвэрт судалгаанаас өмнөх 2 жил дэх үр хөндөлтийг, үр хөндүүлэх үеийн эмэгтэй насаар (тав таван жилээр) нь тодорхойлсон. Харин хуваарьт судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн амьдарсан хүн–жилийн тоог (энгийнээр хэлбэл, эмэгтэйчүүдийн дундаж тоо) судалгааны өмнөх 2 жилээр, эмэгтэйчүүдийн 5 насны бүлгээр ангилж тодорхойлсон. Үр хөндөлтийн нийлбэр коэффициент (ҮХНК) гэдэг нь тухайн насны бүлэг дэх үр хөндөлтийн коэффициент хэвээр хадгалагдана гэж үзвэл нэг эмэгтэй нөхөн үржихүйн амьдралынхаа туршид (15–49 нас) үр хөндөлт хийлгэх тоог тодорхойлдог синтетик арга юм.

ТС.13a ТС.13b	Суулгалт өвчний үед шингэн сэлбэх давсны уусмал болон цайрын бэлдмэл уулгасан байдал		CA	Судалгааны өмнөх 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөн бөгөөд а) шингэн сэлбэх давсны уусмал уусан б) шингэн сэлбэх давсны уусмал болон цайрын бэлдмэл уусан 5 хүртэлх насны хүүхдийн хувь	58.2 13.1
ТС.14	Суулгалт өвчний үед шингэн сэлбэх эмчилгээний зэрэгцээ хоолоо үргэлжлүүлэн идсэн хүүхэд		CA	Судалгааны өмнөх 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөн бөгөөд шингэн сэлбэх эмчилгээ (үйлдвэрийн аргаар бэлтгэж савласан шингэн сэлбэх давсны уусмал болон гэрийн нөхцөлд бэлтгэсэн шингэн сэлбэх уусмал эсвэл шингэн зүйлийг хэвийн хэмжээнээс илүү уух) хийлгэхийн зэрэгцээ хоолоо үргэлжлүүлэн идсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь	71.0
ТС.15	Хоол хийхдээ голчлон хэрэглэж байгаа цэвэр түлш, технологийн хэрэглээ		EU	Хоол болгохдоо цэвэр түлш болон технологи хэрэглэдэг өрхөд амьдардаг хүн амын хувь (гэртээ хоол хийдэг өрхүүдийн хувьд)	50.0
ТС.16	Халаалтандаа голчлон хэрэглэж байгаа цэвэр түлш, технологийн хэрэглээ		EU	Халаалтандаа цэвэр түлш болон технологи хэрэглэдэг өрхөд амьдардаг хүн амын хувь (халаалттай өрхүүдийн хувьд)	31.3
ТС.17	Гэрэлтүүлэгтээ голчлон хэрэглэж байгаа цэвэр түлш, технологийн хэрэглээ		EU	Гэрэлтүүлэгтээ цэвэр түлш болон технологи хэрэглэдэг өрхөд амьдардаг хүн амын хувь (гэрэлтүүлэлттэй өрхүүдийн хувьд)	99.8
ТС.18	Хоол хийх, халаалт, гэрэлтүүлэгтээ голчлон хэрэглэж байгаа цэвэр түлш, технологийн хэрэглээ	7.1.2	EU	Хоол болгох, халаалт болон гэрэлтүүлэгтээ цэвэр түлш болон технологи хэрэглэдэг өрхөд амьдардаг хүн амын хувь ¹¹	31.0
ТС.19	Амьсгалын замын цочмог халдвар (АЗЦХ)-ын шинж тэмдэг илэрсэн үед мэргэжлийн эмчид хандсан байдал	3.8.1	CA	Судалгааны өмнөх 2 долоо хоногт АЗЦХ-ын шинж тэмдэг илэрсэн бөгөөд эмчлүүлэхийн тулд эмнэлэг, мэргэжлийн эмчид хандсан 5 хүртэлх насны хүүхдийн хувь	76.0
ТС.20	АЗЦХ-ын шинж тэмдэг илэрсэн үед антибиотик эмчилгээ хийлгэсэн байдал		CA	Судалгааны өмнөх 2 долоо хоногт АЗЦХ-ын шинж тэмдэг илэрсэн бөгөөд антибиотик эмчилгээ хийлгэсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь	66.6
ТС.30	Эхийн сүүгээр хооллолт		MN	Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, хамгийн сүүлд төрүүлсэн хүүхдээ эхийн сүүгээр хооллож байсан эмэгтэйчүүдийн хувь	98.0
ТС.31	Эрт амлуулалт		MN	Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, хамгийн сүүлд төрүүлсэн хүүхдээ төрсний дараа 1 цагийн дотор амлуулсан эмэгтэйчүүдийн хувь	70.2
ТС.32	Эхийн сүүгээр дагнан хооллолт (6 хүртэлх сар)		BD	Эхийн сүүгээр дагнан хооллож байгаа ¹² 0–5 сартай хүүхдийн хувь	50.2

11 Гэртээ хоол хийдэггүй, халаалт хэрэглэдэггүй, гэрэлтүүлэггүй гэж хариулсан өрхөд амьдардаг хүн амыг хүртвэрээс хасаагүй.

12 Зөвхөн эхийн сүүгээр хооллосон, шингэн сэлбэх давсны уусмал, амин дэм, эрдсийн бэлдмэл болон эмээс бусад ямар нэгэн шингэн зүйл болон хоол идээгүй нялхас.

ТС.33	Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, сүүн бус шингэн ууж байгаа хүүхэд (6 хүртэлх сар)		BD	Судалгааны өмнөх 1 хоногт эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, сүүн бус шингэн уусан ¹³ 0–5 сартай хүүхдийн хувь	61.2
ТС.34	Эхийн сүүгээр 1 нас хүртэл нь үргэлжлүүлэн хооллолт		BD	Судалгааны өмнөх 1 хоногт эхийн сүүгээр хооллосон 12–15 сартай хүүхдийн хувь	80.7
ТС.35	2 нас хүртэлх эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт		BD	Судалгааны өмнөх 1 хоногт эхийн сүүгээр хооллосон 20–23 сартай хүүхдийн хувь	46.3
ТС.36	Эхийн сүүгээр хооллосон голч хугацаа		BD	0–35 сартай нийт хүүхдийн 50 хувь нь судалгааны өмнөх 1 хоногт эхийн сүүгээр хооллоогүй байх нас (сараар)	20.9
ТС.37	Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байгаа хүүхэд		BD	Судалгааны өмнөх 1 хоногт насандаа тохирсон байдлаар ¹⁴ эхийн сүүгээр хооллосон 0–23 сартай хүүхдийн тоо	64.0
ТС.38	Нэмэгдэл хоол (өтгөн, өтгөвтөр, шингэн)–нд орсон хүүхэд		BD	Судалгааны өмнөх 1 хоногт нэмэгдэл хоол (зутан, бантан, томчуудын хоол гэх мэт) идсэн 6–8 сартай хүүхдийн хувь	88.4
ТС.39a ТС.39b	Зохистой байдлаар хооллож байгаа хүүхэд (эхийн сүүгээр хооллодог болон хооллодоггүй)		BD	Судалгааны өмнөх 1 хоногт нэмэгдэл хоолыг зохих давтамжаар, зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан хэрэглэж байгаа 6–23 сартай хүүхдийн хувь (a) эхийн сүүгээр хооллож байгаа хүүхэд (b) эхийн сүүгээр хооллохгүй байгаа хүүхэд	31.8 17.4
ТС.40	Эхийн сүүгээр хооллодоггүй бөгөөд сүүн шингэнийг зохих давтамжаар ууж байгаа хүүхэд		BD	Судалгааны өмнөх 1 хоногт нялхсын сүүн тэжээлийг зохих давтамжаар буюу наад зах нь 2 удаа уусан, эхийн сүүгээр хооллодоггүй 6–23 сартай хүүхдийн хувь	68.4
ТС.41	Зохих нэр төрлийн хүнс хэрэглэж байгаа хүүхэд		BD	Судалгааны өмнөх 1 хоногт зохих төрлийн бүтээгдэхүүн буюу 5 ба түүнээс олон төрлийн хүнсний бүтээгдэхүүний орц бүхий нэмэгдэл хоол ¹⁵ идсэн 6–23 сартай хүүхдийн хувь	39.2
ТС.42	Зохистой давтамжаар идэж байгаа хүүхэд		BD	Судалгааны өмнөх 1 хоногт нэмэгдэл хоолыг (эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдийн хувьд нялхсын сүүн тэжээлийг) зохих давтамжтайгаар ¹⁶ идсэн 6–23 сартай хүүхдийн хувь	65.9
ТС.43	Угжаар хооллолт		BD	Судалгааны өмнөх 1 хоногт угжаар ямар нэг шингэн уусан 0–23 сартай хүүхдийн хувь	36.8
ТС.44a ТС.44b	Тураалтай хүүхэд		AN	Биеийн жин, насны харьцаа нь ДЭМБ–ын боловсруулсан стандарт харьцааны голчоос (a) – 2 стандарт хазайлтаас доогуур (дунд болон хүнд зэргийн) (b) – 3 стандарт хазайлтаас доогуур (хүнд зэргийн) 5 хүртэлх насны хүүхдийн хувь	1.8 0.5

13 Эхийн сүүнээс гадна тодорхой шингэн зүйл (ус, усан суурьтай бусад шингэн, жимсний шүүс, ёслол, зан үйлд хэрэглэгддэг шингэн зүйл үйлдвэрийн болон гэрийн нөхцөлд бэлдсэн шингэн сэлбэх давсны уусмал, дусал, амин дэм, эрдэс болон эм) уусан бөгөөд өөр бусад ямар нэгэн зүйл (ялангуяа, малын гаралтай сүү болон хоолноос гаргасан шингэн буюу шөл) уугаагүй нялхас.

14 Эхийн сүүгээр дагнан хооллосон 0–5 сартай хүүхэд болон эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ нэмэгдэл хоол (өтгөн, хагас өтгөн, шингэн) идэж байгаа 6–23 сартай хүүхэд.

15 Энэ үзүүлэлт нь дараах 8 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээс наад зах нь 5 төрлийг хоол хүнсээрээ ямар нэг хэмжээгээр хэрэглэсэнд суурилан тооцсон: 1) эхийн сүү 2) үр тариа, үндэс болон булцуут ургамал, 3) шош болон самар, 4) өдөр тутмын хэрэглээний цагаан идээ (сүү, тараг, бяслаг), 5) махан бүтээгдэхүүн (мах, загас, тахиа, шувууны мэх болон элэг/ дотор мэх), 6) өндөг, 7) А аминдэмээр баялаг жимс, хүнсний ногоо болон 8) бусад жимс, хүнсний ногоо

16 Эхийн сүүгээр хооллодог хүүхдийн хувьд: Өтгөн, хагас өтгөн, шингэн хоол хүнснийг 6–8 сартай хүүхдийн хувьд 2 удаа, 9–23 сартай хүүхдийн хувьд 3 удаа; Эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдийн хувьд: Өтгөн, хагас өтгөн, шингэн хоол хүнс эсвэл сүүг 4 удаа идсэн 6–23 сартай хүүхэд.

ТС.45a ТС.45b	Өсөлт хоцролтой хүүхэд	2.2.1	AN	Биеийн өндөр, насны харьцаа нь ДЭМБ-ын боловсруулсан стандарт харьцааны голчоос (a) – 2 стандарт хазайлтаас доогуур (дунд болон хүнд зэргийн) (b) – 3 стандарт хазайлтаас доогуур (хүнд зэргийн) 5 хүртэлх насны хүүхдийн хувь	9.4 2.3
ТС.46a ТС.46b	Туранхай хүүхэд	2.2.2	AN	Биеийн жин, өндрийн харьцаа нь ДЭМБ-ын боловсруулсан стандарт харьцааны голчоос (a) – 2 стандарт хазайлтаас доогуур (дунд болон хүнд зэргийн) (b) – 3 стандарт хазайлтаас доогуур (хүнд зэргийн) 5 хүртэлх насны хүүхдийн хувь	0.9 0.3
ТС.47a ТС.47b	Илүүдэл жинтэй хүүхэд		AN	Биеийн жин, өндрийн харьцаа нь ДЭМБ-ын боловсруулсан стандарт харьцааны голчоос (a) + 2 стандарт хазайлтаас дээгүүр (дунд болон хүнд зэргийн) (b) + 3 стандарт хазайлтаас дээгүүр (хүнд зэргийн) 5 хүртэлх насны хүүхдийн хувь	10.5 2.9
ТС.48	Иоджуулсан давсны хэрэглээ		SA	Давстай болон давсгүй өрхөд эзлэх давсны иодын агууламж шалгах тестээр иодит/ иодат эерэг гарсан өрхийн эзлэх хувь	75.1
ТС.49a ТС.49b ТС.49c	Аливааг танин мэдэхэд нь гэр бүлийн гишүүд дэмжлэг үзүүлдэг хүүхэд		EC	Судалгааны өмнөх 3 хоногт доор дурьдсан гэр бүлийнхэн гишүүд 4 ба түүнээс олон төрлөөр аливааг сурах, таних мэдэх болон сургуульд бэлтгэхэд нь цаг гаргасан 24–59 сартай хүүхдийн хувь, (a) өрхийн насанд хүрсэн хэн нэг гишүүн (b) эцэг (c) эх	57.6 15.6 37.7
ТС.50	Хүүхэд зориулсан номын хүртээмж		EC	3 ба түүнээс олон тооны өөрт нь зориулсан хүүхдийн номтой 5 хүртэлх насны хүүхдийн хувь	28.6
ТС.51	Хүүхдийн тоглоомын хүртээмжтэй байдал		EC	2 ба түүнээс олон төрлийн тоглоом (гар эсвэл үйлдвэрийн аргаар хийсэн) эсвэл түүнийг орлуулах зүйлээр (аяга, таваг гэх мэт гэр ахуйн эд зүйл эсвэл мод, чулуу гэх мэт гадны эд зүйл) тоглодог 5 хүртэлх насны хүүхдийн хувь	65.1
ТС.52	Насанд хүрэгчдийн хараа хяналтгүй гэртээ үлдсэн хүүхэд		EC	Судалгааны өмнөх 7 хоногт наад зах нь 1 цагаас илүү хугацаагаар ганцааранг нь эсвэл 10 хүртэлх насны хүүхдээр харуулж үлдээсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь	12.5
ТС.53	Бага насны хүүхдийн хөгжлийн индекс	4.2.1	EC	Унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар, бие бялдрын хөгжил, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар, сурах чадвар нь зохих хэмжээнд байгаа 36–59 сартай хүүхдийн хувь	75.7
ТС.S1	Бага насны хүүхдийн хөгжлийн индекс (өөрийн улс орны онцлогт суурилж тооцсон)		EC	Унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар, бие бялдрын хөгжил, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар, сурах чадвар нь зохих хэмжээнд байгаа 36–59 сартай хүүхдийн хувь (МУ-ын онцлогт суурилж тооцсон үзүүлэлт нь стандарт тодорхойлолтоос ялгаатай нь <i>унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадварт</i> үсэг таних, энгийн үг унших чадварыг хасч, өнгө, энгийн дүрс ялгаж таних чадварыг нэмж тооцсон бол <i>бие бялдрын хөгжилд</i> эрхий, долоовор, дунд хуруугаараа жижиг зүйлийг барьж чадвар зэргийг нэмж тооцсон.)	87.5

БОЛОВСРОЛ					
LN.1	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт		UB	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж (цэцэрлэг эсвэл хувилбарт сургалт) байгаа 36–59 сартай хүүхдийн хувь	73.6
LN.2	Боловсролын хөтөлбөрт хамран сургалтын цэвэр жин (засварласан)	4.2.2	ED	Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр (цэцэрлэг, хувилбарт сургалт) болон бага ангид сурч байгаа 5 настай хүүхдийн хувь	84.3
LN.3	Сургуульд бэлтгэгдсэн байдал		ED	Судалгааны үед 1–р ангид суралцаж байсан бөгөөд судалгаа авах үеийн өмнөх хичээлийн жилд цэцэрлэг эсвэл хувилбарт сургалтад хамрагдаж байсан хүүхдийн хувь	85.0
LN.4	Бага боловсролд элсэлтийн цэвэр жин		ED	Судалгааны үеийн хичээлийн жилд 1–р ангид элсэн орсон сургуульд орох насны хүүхдийн хувь	92.0
LN.5a	Бага боловсролд хамран сургалтын цэвэр жин (засварласан)		ED	(а) Бага ангид сурах насны бага болон дунд ангид сурч байгаа	96.1
LN.5b				(b) Дунд ангид сурах насны дунд болон түүнээс дээш түвшний боловсролд хамрагдаж байгаа	93.0
LN.5c				(c) Ахлах ангид сурах насны ахлах болон түүнээс дээш түвшний боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн хувь	86.5
LN.6a	Сургууль завсардалтын түвшин (суурь боловсрол)		ED	(а) Бага ангид сурах насны бага болон дунд ангид сурахгүй байгаа	3.6
LN.6b				(b) Дунд ангид сурах насны дунд болон ахлах ангид сурахгүй байгаа	4.6
LN.6c				(c) Ахлах ангид сурах насны бага, дунд, ахлах анги болон түүнээс дээш түвшний боловсролд хамрагдан сурахгүй байгаа хүүхдийн хувь	12.8
LN.7a	Боловсрол эзэмшилтийн (сүүлийн ангид сурч байгаа хүүхдийн) бохир жин		ED	(а) Бага боловсролын	92.5
LN.7b				(b) Суурь боловсролын төгсөх ангид сурч байгаа (улиран сурагчдыг оруулаагүй) тухайн ангид суралцах насны хүүхдийн хувь	98.6
LN.8a	Төгсөлтийн түвшин		ED	(а) Бага боловсролын	98.4
LN.8b				(b) Суурь боловсролын	92.1
LN.8c				(c) Бүрэн дунд боловсролын төгсөх ангийг дүүргэсэн/ төгссөн тухайн шатны сүүлийн ангид хамрагдвал зохих наснаас 3–5 насаар ахмад хүүхдийн тоо	70.5
LN.9	Дунд ангид дэвшин суралцсан хүүхэд		ED	Судалгааны үед 6–р (дунд ангийн эхний) ангид суралцаж байсан бөгөөд өмнөх хичээлийн жилд 5–р (бага ангийн төгсөх) ангид суралцаж байсан хүүхдийн хувь	9.3
LN.10a	Нас хоцрон суралцагчид		ED	(а) Бага ангид	0.3
LN.10b				(b) Дунд ангид суралцаж байгаа бөгөөд тухайн суралцаж буй ангид суралцах наснаас 2 ба түүнээс дээш насаар ах сурагчдын хувь	0.7

LN.11a LN.11b LN.11c	Боловсролын тэгш байдлын индекс (a) Хүйсийн (b) Аж байдлын (c) Хот хөдөөгийн	4.5.1	ED	Охидын хамран сургалтын цэвэр жин (засварласан) болон хөвгүүдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа (a) Бага анги (b) Дунд анги (c) Ахлах анги	1.02 1.03 1.13
				Доогуур аж байдалтай (хамгийн доод 20%) өрхөд амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жинг (засварласан) болон Дээгүүр аж байдалтай (хамгийн дээд 20%) өрхөд амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа (a) Бага анги (b) Дунд анги (c) Ахлах анги	1.00 0.97 0.74
				Хөдөө амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жин болон (засварласан) хотод амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа (a) Бага анги (b) Дунд анги (c) Ахлах анги	1.02 1.00 0.82
LN.12	Хүүхдийн дүнгийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал		PR	Эцэг, эхчүүдэд мэдээлэл өгөх зорилгоор сурагчийн дүнгийн хуудас/ мэдээлдэг сургуульд сурдаг 7–14 насны хүүхдийн хувь	81.0
LN.13	Сургуулийн зөвлөлд оролцох боломж		PR	Сургуулийн зөвлөлд эцэг, эхчүүд оролцдог сургуульд сурдаг 7–14 насны хүүхдийн хувь	51.4
LN.14	Сургуулийн удирдлагын үйл ажиллагаан дахь оролцоо		PR	Өрхийн насанд хүрсэн гишүүн сургуулийн зөвлөлийн хуралд оролцсон 7–14 насны сургуульд сурдаг хүүхдийн хувь	22.6
LN.15	Сургуулийн удирдлагын үйл ажиллагаанд үр дүнтэй оролцсон байдал		PR	Боловсрол (сургуулийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм)/ сургуулийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт санхүүгийн асуудлыг хэлэлцсэн сургуулийн зөвлөлийн хуралд өрхийн насанд хүрсэн гишүүн нь оролцсон 7–14 насны сургуульд сурдаг хүүхдийн хувь	18.8
LN.16	Сургуулийн удирдлагын үйл ажиллагаанд үр дүнтэй оролцсон байдал		PR	Өрхийн насанд хүрсэн гишүүн нь хүүхдийн суралцаж буй үйл явцын талаар багштай нь ярилцсан 7–14 насны сургуульд сурдаг хүүхдийн хувь	82.2
LN.17	Багш нарын ажил хаялт эсвэл багш нь ирээгүй талаар сургуультай холбоо барьсан байдал		PR	Багш ажил хаясан, эсвэл тасалснаас болоод хүүхэд хичээлдээ яваагүй тохиолдолд өрхийн насанд хүрсэн гишүүн сургуультай холбоо барьсан 7–14 насны сургуульд сурдаг хүүхдийн хувь	24.8
LN.18	Гэртээ ном унших боломж		PR	Гэртээ 3 ба түүнээс олон унших номтой 7–14 насны хүүхдийн хувь	49.6
LN.19	Гэртээ ном унших дадал		FL	Гэртээ ном уншдаг/хүнээр уншуулдаг 7–14 настай хүүхдийн хувь	78.8
LN.20	Гэр болон сургуульд хэрэглэгддэг хэл		FL	Гэртээ ярьдаг хэлээ сургууль дээр ашигладаг сургуульд сурдаг 7–14 насны хүүхдийн хувь	97.4
LN.21	Гэрийн даалгавар хийхэд нь үзүүлж буй дэмжлэг		PR	Гэрийн даалгавар хийхдээ тусламж авсан 7–14 насны сургуульд сурдаг хүүхдийн хувь	65.2

LN.22a	Унших болон тоо бодох суурь чадвартай хүүхэд	4.1.1	FL	3 унших дасгалыг зөв уншсан хүүхдүүдийн хувь		
LN.22b				(a) 7–14 насныхан		61.6
LN.22c				(b) 2, 3–р ангид сурах насныхан		46.4
LN.22d				(c) 2, 3–р ангид суралцагчид		44.4
LN.22e				4 тооны дасгалыг зөв хийсэн хүүхдүүдийн хувь		51.5
LN.22f				(d) 7–14 насныхан		35.7
				(e) 2, 3–р ангид сурах насныхан	33.6	
				(f) 2, 3–р ангид суралцагчид		

ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГӨӨС ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

PR.1	Төрсний бүртгэл	16.9.1	BR	Төрсний гэрчилгээтэй 5 хүртэлх насны хүүхдийн хувь	99.6
PR.2	Сэтгэл зүйн болон бие махбодын шийтгэл хүлээсэн хүүхэд	16.2.1	UCD – FCD	Судалгааны өмнөх 1 сард эцэг/эх/асран хамгаалагчийн зүгээс сэтгэл зүйн болон бие махбодын шийтгэл хүлээсэн 1–14 насны хүүхдийн хувь	49.1
PR.3	Хүүхдийн хөдөлмөр	8.7.1	CL	Хөдөлмөр эрхэлдэг 5–17 насны хүүхдийн хувь ¹⁷	16.7
PR.4a	Эрт гэрлэлт	5.3.1	MA	Эмэгтэй	
PR.4b				(a) 15 нас	
				(b) 18 нас	12.0
				Эрэгтэй	
				(a) 15 нас	
				(b) 18 нас	2.1
				хүрэхээсээ өмнө гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай болсон 20–24 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь	
